



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 24

Мандалговь

Г

Г

**А.Мөнх-Эрдэнийг албан тушаалд нэр
дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Ариунзулын Мөнх-Эрдэнэ 89.8 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.


Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа А.Мөнх-Эрдэнийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

2020021052



Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн Ариунзулын Мөнх-Эрдэнийн тухай дүгнэлт

1. А.Мөнх-Эрдэнэ нь 1996 онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвд төрсөн. 24 настай. Эрэгтэй.
2. Боловсролын байдал: Монгол улсын Боловсролын Их сургуулийг 2013-2017 онд Аялал жуулчлалын бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. Спорт, аялал жуулчлал мэргэжилтэй.
3. Ажлын туршлага: 2017-2018 онд аймгийн Музейд үйлчилгээний зохион байгуулагч, 2018 оноос аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт байгаль хамгаалагчаар ажиллаж байгаа.
4. А.Мөнх-Эрдэнийн төрийн захиргааны албанд ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ